

Сампилноров буюу эрдэний үрэл эмийн задлалын судалгаа

Ли Чан Шин¹, Ч.Ерөөлт², Д.Даваадагва¹

¹АШУУИС, Эм зүйн сургууль, Эмийн технологийн тэнхим

²АШУУИС, Био-Анагаахын сургууль, Эм судлалын тэнхим

Цахим шуудан: 1554086502@qq.com, Утас: 90531451

Түлхүүр үг:

Цагаан судал
Хорогдсон
Төлжүүлэх
Тэгшитгэх

Товч утга:

Үндэслэл: Сампилноров үрэл эмийн тухай “БНХАУ-ын анагаах ухааны нэвтэрхий толийн Монгол анагаах ухаан”-д “Тус найрлага нь хуучирсан халууныг арилгах, цагаан судлын гэмтлийг арилгах, шар усыг арилгах чадалтай голдуу хар цагаан судлын өвчин саа, тулай, хэрэх, хижиг хямарсан, халуун хуучирч судалд шунасан, уяман, бөөрний судал доргисон, бөөрний халуун, судал шөрмөс таталдах, үе мөч тахийх зэргийг анагаана” гэсэн байдаг. **Зорилго:** Сампилноров үрэл эмийн найрлагын эмт бодисын амтын эрдэм, шингээлтийн эцсийн амтын эрдэм, эмт бодисын чадал, таван махбодиос үүссэн эрдэм зэрэг 4 зүйлээр хий, шар, бадганы хорогдолыг нөхөн төлжүүлэх ёсыг бодитой задалж үзүүлэх. **Арга, аргачлал:** Сампилноров үрэл эмийн талаар уламжлалт анагаах ухааны хэрэглээний талаарх мэдээлэлийг агуулсан Хятад, Төвд, Монголын анагаах ухааны түүхийн зохиолууд болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Дөрвөн рашаан” зэрэг гол зохиолуудыг тулгуурлав. Түүхийн харьцуулах арга /историко- сравнительный/, Түүхийн төрөлжүүлэлтийн арга, Анализ- синтезийн арга буюу задлан шинжилж нэгтгэн дүгнэх арга, Герменевтик арга зүйг ашиглан хийж гүйцэтгэв. **Үр дүн:** Тус найрлага амтын эрдмээр амь баригч хий, дээш гүйгч хий, гал тэгштгэгч хийг их хэмжээгээр нөхөн төлжүүлэх бөгөөд түгээмэл гүйгч хий, урвуу арилгагач хийг бага хэмжээгээр нөхөн төлжүүлж, гадар дотор, завсар бүхний хийн гүйдлийг түргэтгэж бодисын солилцоог нэмэгдүүлж, бүтээгч шар, шингээгч шарын хүчийг их хэмжээгээр нөхөн төлжүүлж, бусад шарыг бага хэмжээгээр нөхөн төлжүүлэнэ. Шүтүүлэгч бадганы усыг их хэмжээгээр, хангагч бадганыг дунд хэмжээгээр, бусад бадганы зөөлөн батлаг, наалдангуй болон шүлсний хорогдолыг тус тус нөхөн төлжүүлнэ. **Дүгнэлт:** Дээрх 29 нь хөл эмийн найрлага нь 6 амт, 8 чадал, 17 зүйлийн эрдэм, шингээлтийн эцсийн амтаар бүрэлдсэн, амтын эрдмээр хий, шар, бадганыг их, дунд, бага хэмжээгээр нөхөн төлжүүлэхэд тус тус оролцсон байна.

Үндэслэл: Сампилноров үрэл эм нь сэрүүн чанартай, тархи нугасны гэмтэл, цусны даралт өндөр зэрэг удаан засагдах, нилээд төвөгтэй цагаан судлын өвчинд тохитой ерөндөг болох тул нилээд олон хөл эмийг найруулан бэлтгэсэн байдаг¹. Үүнд тайтгаруулах, тархи цагаан судлын гэмтлийг анагаах сувдаар¹ гололсон, халууны урхагыг гаргах гиван, нян нядлаж, хорын халууныг арилгах, сүвийг нээх хүдрийн заар, судлын халууныг арилгахад чихэр өвсний үндэс, амин судлын хий өвчинд голт борыг, зүрхний хийн халууныг арилгахад хар агарыг, цул савны өвчнийг засах,

махбодыг тэгшитгэхэд задь, сүгмэл, хулсан жуган, гүргүм, гагол зэргийг, шар усыг хатаахад хирсний эвэр, малгайн залаа өвс, шар усны гурван эм, барүүр, уушги, зүрхний хямарсан халууныг арилгахад цагаан занданг, цусны халууныг арилгахад улаан зандан, жүрүүрийг нэмэрлэж халуун хуучирч, судалд сарнисан тулай, хэрэх өвчин зэрэгт тустай. Эдгээр халууныг арилгах хөл эмүүдийн дээр шээлгэх үйлдэл бүхий алтан элс, наймаалж зэргийг хавсруулан өвчний урхагыг шээсний замаар арилган гаргаж бөөрний халуун өвчинд тустай, хий цус хямарсаныг дарах, өвдөхийг зогсооход руда,

мана зэргийг элэг ходоодны хүйтэн хийг арилгахад хар сайр, гаврын хальсыг, махбодыг тэгшитгэж шингээлтийг сайжруулахад дээрх 29 зүйлийн эм нь амтлаг, халуун, амт хийгээд, сэрүүн, хөнгөн, хуурай, ширүүн, зөөлөн, эелдэг, тэгш чанар бүхий найрлага болсон тул цагаан судлын өвчин хийгээд халуун хуучирч шунасанд маш тустай байдаг¹⁻³. Иймээс хий, шар, бадгана харьцангуй тэнцвэрээ алдаж хорогдох өвчин зүй бол туйлын нарийн будилантай бөгөөд харьцангуй тэнцвэртэй байх бүрэлдэхүүнийг нь үл хорлон, харьцангуй тэнцвэрээ адил бус хэмжээгээр алдсан бүрэлдэхүүнийг нь тодорхой хэмжээгээр нөхөн төлжүүлэхийн тулд эмт бодисуудыг олон хөл эмээр найруулан хэрэглэж махбод, тамир, хирийн хямралыг тэгшитгэдэг тул уламжлалт анагаах ухаанд хэрэглэддэг сапилноров үрэл эмэнд задлал хийх нь судалгааны ажлын үндэслэл болсон².

Зорилго: Сампилноров үрэл эмийн найрлагын эмт бодисын амтын эрдэм, шингээлтийн эцсийн амтын эрдэм, эмт бодисын чадал, таван махбодиос үүссэн эрдэм зэрэг 4 зүйлээр хий, шар, бадганы хорогдолыг нөхөн төлжүүлэх ёсыг бодитой задалж үзүүлэх.

Зорилт:

1. Тус найрлага дахь эмт бодис тус бүрийн эмийн амт дагалдсан эрдмийг задлан эрдэм, шингээлтийн эцсийн амтаар хий, шар, бадганыг хэрхэн төлжүүлдэгийг задлан үзүүлэх
2. Тус найрлага нь амтын эрдмээр хий, шар, бадганы хорогдолыг төлжүүлэх үйлдлийг задлан тодорхойлох.
3. Сампилноров үрэл эмийн эдмийн хийг нөхөн төлжүүлэх, шарыг нөхөн төлжүүлэх, бадганыг нөхөн төлжүүлэхэд оролцсон эмийн их, дунд, бага хэмжээг задлан тодорхойлох.

Арга, аргачлал: Сампилноров үрэл эмийн талаар уламжлалт анагаах ухааны хэрэглээний талаарх мэдээлэлийг агуулсан Хятад, Төвд, Монголын анагаах ухааны түүхийн зохиолууд болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Дөрвөн рашаан” зэрэг гол зохиолуудыг тулгуурлав. Нийгэм, соёл иргэншил, улс төр, шашин, мэдлэг ухааны салбарууд(шинжлэх ухаан) гэх мэт асуудлууд нь хоорондоо уялдаатай байдаг тул ямар нэгэн түүхийг судлахад нийтлэг, бүгдэд тохирох түгээмэл арга, арга зүй гэж байдаггүй тухай эрдэмтдийн бүтээлд дурдагджээ. Түүхийн судалгаанд хэдэн арван арга, арга зүй байдаг ба бид түүхийн шинжлэх ухааны судалгаанд хэрэглэгддэг дараах үндсэн аргуудыг уялдуулан хэрэглэв. Үүнд:

Түүхийн харьцуулах арга /историко- сравнительный: Энэ аргын мөн чанар нь түүхийн үйл явдал, үзэгдэл, явцыг хооронд нь харьцуулснаар 1-рт судалж байгаа зүйлийн мөн чанарыг баримтанд түшиглэн мэдэх, 2-рт баримтыг тайлбарлах, 3-рт дотоод шинж чанарын ерөнхий, давтагдах, ижил төсөөтэй, ялгаатай, чухал, зүй тогтолт талууд болон орон зай, цаг хугацааны өөр байдлыг нь олж харах, 4-рт түүнчлэн ижил төстэй зүйлүүд боловч агуулгаараа ялгаатай байх зэргийг

мэдэх боломжийг олгодогт оршино.⁴

Түүхийн төрөлжүүлэлтийн арга: Үзэгдэл хийгээд объектүүдийн бүрдлийг тэдгээрийн нийтлэг гол шинжүүдэд нь үндэслэн тодорхой төрөл болон цэгцлэх зорилготой шинжлэх ухааны танин мэдэхүйн аргыг төрөлжүүлэлт гэдэг. Индукци /үндэслэлийг нэгтгэж ерөнхийлөн дүгнэх/, дедукци /өөрчлөн нотлох, ерөнхийд тулгуурлан онцгойг нотлох/ буюу нэгтгэн дүгнэх, өөрчлөн нотлох хандлагын /аргын/ үндсэн дээр түүхийн төрөлжүүлэлтийн арга нь бодитой болно.^{4,5}

Анализ- синтезийн арга буюу задлан шинжилж нэгтгэн дүгнэх арга: Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу юмс үзэгдлийг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хуваана. Ингэснээрээ тухайн объектийн хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гардаг. Анализ хийж объектийг задлан шинжилснийг шууд дагалдаж зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм. Судалгааныхаа объектийг бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан хувааж хэсэг тус бүрийн шинж чанарыг тодотгосныхоо дараа тэдгээрийг сэтгэхүйдээ эргэн нэгтгэж бүхэл цогц оюун дүгнэлт төсөөллийг үүсгэнэ. Энэ үйлдэл нь синтез юм.⁵⁻⁶ Бид энэ аргад үндэслэн эх зохиолуудад дахь найрлагыг мэдээллийн сурвалжуудыг харьцуулаад гарсан үр дүнг задлан шинжилж зохих дүгнэлтүүдийг хийв.

Герменевтик арга зүй: Герменевтик гэдэг нь тайлбарлах, тодруулах гэсэн утгатай грек үгнээс гаралтай бөгөөд домгийн өгүүлэмжүүд, шашны хөлгөн судрууд, эртний соёлын дурсгалт зүйлсүүдийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулан хөврүүлэх зэрэг зорилтуудтай уялдан герменевтикийн арга зүйг боловсруулсан⁷⁻⁸. Герменевтикийг түүхийн судалгаанд хэрэглэхдээ аливаа бичвэр- санааны утгыг зөв тогтоохын тулд зохиогчийн хэрэглэсэн нэр томъёо, үгний утгын оноолтыг тодорхойлох шаардлагатай болдог. Герменевтик арга зүйн гол баримтлал бол зохиогчийг өөрөөс нь илүү ойлгож болох буюу зохиогчийн ухамсарлаж бодоогүй, гол зорилт болгон тавиагүй далд нуугдмал утга санааг илрүүлж болох явдал юм.⁷⁻⁸

Үр дүн: Сампилноров үрэл эм нь сэрүүн чанартай, тархи нугасны гэмтэл, цусны даралт өндөр зэрэг удаан засагдах, нилээд төвөгтэй цагаан судлын өвчинд тохитой ерөндөг, болох тул нилээд олон хөл эмийг найруулан бэлтгэсэн байдаг. Үүнд тайтгаруулах, тархи цагаан судлын гэмтлийг анагаах сувдаар гололсон, халууны урхагыг гаргах гиван, нян нядлаж, хорын халууныг арилгах, сүвийг нээх хүдрийн заар, судлын халууныг арилгахад чихэр өвсний үндэс, амин судлын хий өвчинд голт борыг, зүрхний хийн халууныг арилгахад хар агарыг, цул савны өвчнийг засах, махбодыг тэгшитгэхэд задь, сүгмэл, хулсан жуган, гүргүм, гагол зэргийг, шар усыг хатаахад хирсний эвэр, малгайн залаа өвс, шар усны гурван эм, барүр, уушги, зүрхний хямарсан халууныг арилгахад цагаан занданг, цусны халууныг арилгахад улаан зандан, жүрүүрийг нэмэрлэж халуун хуучирч, судалд сарнисан

тулай, хэрэх өвчин зэрэгт тустай^{1-3,11-14,17}. Эдгээр халууныг арилгах хөл эмүүдийн дээр шээлгэх үйлдэл бүхий алтан элс, наймаалж зэргийг хавсруулан өвчний урхагыг шээсний замаар арилган гаргаж бөөрний халуун өвчинд тустай, хий цус хямарсаныг дарах, өвдөхийг зогсооход руда, мана зэргийг элэг ходоодны хүйтэн хийг арилгахад хар сайр, гаврын хальсыг, мах

бодыг тэгшитгэж шингээлтийг сайжруулахад дээрх 29 зүйлийн эм нь амтлаг, халуун, амт хийгээд, сэрүүн, хөнгөн, хуурай, ширүүн, зөөлөн, эелдэг, тэгш чанар бүхий найрлага болсон тул цагаан судлын өвчин хийгээд халуун хуучирч шунасанд маш тустай¹⁸. Эмийн найрлагын бүрэлдэхүүнийг хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Сампилноров эмийн найрлагын бүрэлдэхүүн

Д/д	Түүхий эд	Хэмжээ
1	Сувд	0.07g
2	Улаан зандан	0.278g
3	Задь	0.042g
4	Гиван	0.036g
5	Жүр үр	0.036g
6	Усан үхрийн эвэр	0.036g
7	Чихэр өвс	0.028g
8	Малгайн залаа өвс	0.028g
9	Гэмийн үр	0.028g
10	Талгадорж	0.028g
11	Цагаан гүгэл	0.028g
12	Хач гүргэм	0.024g
13	Голт бор	0.024g
14	Сүгмэл	0.024g
15	Хар сайр	0.024g
16	Цагаан сайр	0.024g
17	Библин	0.024g
18	Алтан элс	0.024g
19	Наймаалж	0.024g
20	Ар үр	0.024g
21	Бар үр	0.024g
22	Заар	0.021g
23	Цагаан зандан	0.021g
24	Хар агар	0.021g
25	Гаврын хальс	0.018g
26	Руда	0.014g
27	Мана	0.014g
28	Хонилон	0.007g
29	Жуган	0.007g
30	Гагол	0.007g

Сампилноров үрэл эмийн найрлага дахь эмт бодисуудын амт, эрдэм, шингээлтийн эцсийн амтыг хүснэгт 2- оор үзүүлэв.

Хүснэгт 2. Сампилноров үрэл эмийн амт, эрдэм, шингээлийн амт

Жорын найрлаганд орсон түүхий эд	Найрлага дахь эмт бодисын амт	Найрлага дахь эмт бодисын эрдэм	Эмт бодисын шингээлтийн амт
Сувд	эхүүн, амтлаг, давслаг	хүнд, мохдог, хуурай, ширүүн, хурц, шингэн, бүлээн	амтлаг, эхүүн
Гиван	гашуун, амтлаг	хуурай, ширүүн, хурц, шингэн, бүлээн	гашуун
Усны үхрийн эвэр	гашуун, исгэлэн, давслаг	сэрүүн, хуурай, хөлбөрөнхүй, ширүүн, хүнд, мохдог, бүлээн	гашуун
Жүрүр	исгэлэн	сэрүүн, мохдог, ширүүн	амтлаг
Шинц	гошгуун, эхүүн	хөнгөн, ширүүн, хуурай, хөлбөрөнхүй, хурц, халуун	амтлаг
Талгадорж	гашуун, эхүүн	сэрүүн, мохдог, ширүүн, хуурай	гашуун
Сомаранз	гошгуун, гашуун	хөнгөн, ширүүн, хуурай, хөлбөрөнхүй	гашуун
Ларьз	гашуун	сэрүүн, мохдог, хөнгөн, ширүүн, тослог	гашуун
Цагаан зандан	эхүүн бага зэрэг гашуун	сэрүүн, мохдог, хөнгөн, ширүүн, хүйтэн	гашуун
Рүда	гошгуун, амтлаг	тослог, ширүүн, хөнгөн, бүлээн	гошгуун
Гүргүм	амтлаг бөгөөд өчүүхэн гашуун	сэрүүн, мохдог, зөөлөн, батлаг, эелдэг	амтлаг
Лиш	гошгуун, эхүүн, үл мэдэгдэм гашуун	тослог, батлаг, зөөлөн, бүлээн, хуурай, хүнд	гошгуун
Барүр	эхүүн	хөнгөн, сэрүүн, хожигор, мохдог, хуурай	амтлаг, гошгуун
Цагаан сайр	амтлаг, гошгуун	хөнгөн, ширүүн, сэрүүн, мохдог, хуурай	амтлаг
Бибилін	гошгуун	хуурай, бүлээн тослог	амтлаг
Дигсрэн	давслаг бөгөөд амтлаг	тослог, ширүүн, хуурай, хожигор, шингэн, эелдэг хурц	амтлаг
Шинар	амтлаг, өчүүхэн гашуун	сэрүүн, шингэн, хөнгөн, эелдэг, зөөлөн	амтлаг
Хар сайр	гошгуун, эхүүн, амтлаг	хөнгөн, бүлээн, хуурай, ширүүн	гошгуун
Улаан зандан	эхүүн	сэрүүн, мохдог, хүнд, ширүүн, хүйтэн	гашуун
Бойгар	эхүүн бөгөөд бага зэрэг амтлаг	сэрүүн, хөнгөн хожигор, хуурай, хурц	гошгуун
Брэдсазэн	эхүүн, амтлаг	бүлээн, хөлбөрөнхүй, мохдог	амтлаг
Сэржижима	гашуун, гошгуун	хөнгөн, ширүүн, хүйтэн, мохдог, хурц	амтлаг
Задь	амтлаг, гошгуун	хүнд, тослог, зөөлөн, бүлээн	амтлаг, гошгуун
Жуган	амтлаг	хүнд, мохдог, сэрүүн, зөөлөн, эелдэг	амтлаг
Гагол	амтлаг, гошгуун	хөнгөн, бүлээн, халуун, хуурай, ширүүн	амтлаг
Сүгмэл	амтлаг, гошгуун	тослог, бүлээн, хуурай, хурц, халуун	гошгуун
Хар агар	гашуун, гошгуун	хүнд, мохдог, сэрүүн, тослог, зөөлөн, эелдэг	гашуун
Мана	гашуун, гошгуун	хүнд, мохдог, сэрүүн, хөнгөн	гашуун
Арүр	эхүүн, гашуун	хүнд, тослог, хүйтэн, мохдог, халуун, хурц, хөнгөн, ширүүн	амтлаг

Хүснэгтээс үзэхэд дээрхи хөл эмүүдийн задлалтыг үндэслэвэл: Дээрх 29 нь хөл эмийн найрлага нь 7 эхүүн, 7 гашуун, 1 исгэлэн, 8 амтлаг, 5 халуун, 1 давслаг амтаар бүрэлдсэн. 10 хүнд, 17 мохдог, 14 хуурай, 16 ширүүн, 7 хурц, 3 шингэн, 10 бүлээн, 15

сэрүүн, 7 зөөлөн, 6 эелдэг, 4 хөлбөрөнхүй, 14 хөнгөн, 4 халуун, 9 тослог, 4 хүйтэн, 2 батлаг, 3 нүнжигтүй нийт 17 зүйлийн эрдэм бүгд оролцсон байна. Тус найрлагын амтын эрдмээр хий, шар, бадганыг төлжүүлэхийг хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгт 3. Сампилноров үрэл эмийн амтын эрдмээр хий, шар, бадганыг төлжүүлэлт

Төлжүүлэх эрдэм	Төлжүүлэгдэх махбод
14 хуурай, 16 ширүүн, 15 сэрүүн, 4 хөлбөрөнхүй, 14 хөнгөн, 3 нүнжиггүй эрдмийн хүчээр	хийн билиг чанарын хорогдолыг төлжүүлж, гүйдлийг нь сайжруулан, хийн солилцоог нэмэгдүүлэнэ
7 хурц, 10 бүлээн, 4 халуун, 9 тослог эрдмийн хүчээр	шарын билиг чанарын хорогдолыг
10 хүнд, 17 мохдог, 3 шингэн, 7 зөөлөн, 6 эелдэг, 9 тослог, 4 хүйтэн, 2 батлаг эрдмийн хүчээр	бадганы билиг чанарын хорогдолыг нөхөн төлжүүлэх

Хүснэгтээс үзэхэд Тус найрлага нь амтын эрдмээр хий, шар, бадганыг төлжүүлэхдээ 14 хуурай, 16 ширүүн, 15 сэрүүн, 4 хөлбөрөнхүй, 14 хөнгөн, 3 нүнжиггүй эрдмийн хүчээр хийн билиг чанарын хорогдолыг нөхөн төлжүүлж, гүйдлийг нь сайжруулан, хийн солилцоог нэмэгдүүлэнэ. 7 хурц, 10 бүлээн, 4 халуун, 9 тослог эрдмийн хүчээр шарын билиг чанарын хорогдолыг, 10 хүнд, 17 мохдог, 3 шингэн, 7 зөөлөн, 6 эелдэг, 9 тослог, 4 хүйтэн, 2 батлаг эрдмийн хүчээр бадганы билиг чанарын хорогдолыг тус тус нөхөн төлжүүлжээ.

“БНХАУ-ын анагаах ухааны нэвтэрхий толийн Монгол анагаах ухаан”-д “Тус найрлага нь хуучирсан халууныг арилгах, цагаан судлын гэмтлийг арилгах, шар усыг арилгах чадалтай голдуу хар цагаан судлын өвчин саа, тулай, хэрэх, хижиг хямарсан, халуун хуучирч судалд шунасан, уяман, бөөрний судал доргисон, бөөрний халуун, судал шөрмөс таталдах, үе мөч тахийх зэргийг анагаана” гэсэн байдаг¹.

Тус найрлага амтын эрдмээр амь баригч хий, дээш гүйгч хий, гал тэгшитгэгч хийг их хэмжээгээр нөхөн төлжүүлэх бөгөөд түгээмэл гүйгч хий, урвуу арилгагч хийг бага хэмжээгээр нөхөн төлжүүлж, гадар дотор, завсар бүхний хийн гүйдлийг түргэтгэж бодисын солилцоог нэмэгдүүлж, бүтээгч шар, шингээгч шарын хүчийг их хэмжээгээр нөхөн төлжүүлж, бусад шарыг бага хэмжээгээр нөхөн төлжүүлэнэ¹⁻². Шүтүүлэгч бадганы усыг их хэмжээгээр, хангагч бадганыг дунд хэмжээгээр, бусад бадганы зөөлөн батлаг, наалдангуй болон шүлсний хорогдолыг тус тус нөхөн төлжүүлэх бөгөөд хий ба шарыг нөхөн төлжүүлсэний суурин дээр бадганы хөдөлгөөнийг сайжруулж, хийн хүчээр саринуулан бадганы шинээр бий болгох шүлсийг нөхөн төлжүүлж, усны солилцоо, галын илч, хийн солилцоог нэмэгдүүлсэнийг хүснэгт 4-өөр харуулав.

Хүснэгт 4. Сампилноров үрэл эмийн хий, шар, бадганыг нөхөн төлжүүлэхэд оролцсон эрдмийн хувь болон их, бага, дунд хэмжээ

Төлжүүлэгдэх махбод	Эрдмийн (%)	Их, дунд, бага хэмжээ
Хий махбод	7%	Их
Шар махбод	3%	Бага
Бадгана махбод	6%	Дунд

Хүснэгтээс үзэхэд хийг нөхөн төлжүүлэхэд оролцсон эрдэм нь 7%, шарыг нөхөн төлжүүлэхэд оролцсон эрдэм нь 3%, бадганыг нөхөн төлжүүлэхэд оролцсон эрдэм нь 6% болно.

Хэлцэмж: Тус найрлагын өөрийн чадлаар хий, шар, бадганыг нөхөн төлжүүлэхэд сувд бол тархи бэртсэнийг анагаах бөгөөд хангагч бадгана, шүтүүлэгч бадгана, гал тэгшитгэгч хий, бүтээгч шар хийгээд өнгө урвуулагч шарын хорогдол ба бадганы зөөлөн наалдангуй билиг чанарын хорогдолыг нөхөн төлжүүлдэг.¹ Талгадорж бол арьсаны өвчнийг анагаах бөгөөд өөрийн эрдмээр арьсанд оршисон гал тэгшитгэгч хий, шүтүүлэгч бадганы шингэн салсыг нөхөн төлжүүлж, хийн гүйдлийг ихээр сайжруулана¹⁻². Мөн ширүүн эрдмээр урвуу арилгагч хийг нөхөн төлжүүлж шээлгэх, цусанд оршисон гал тэгшитгэгч хийг нөхөж цусны тунгалаг цөвийг ялгаруулах үйлдэлтэй². Сомранз бол голдуу арьсаны хийг нөхөн гүйлгэж арьс, цусны тунгалаг цөвийг ялгана³. Дигсрэн бол шээлгэх бөгөөд хийг гүйлгэж доод биеийн бадганы шингэн билиг чанарыг нөхөн төлжүүлэнэ. Брэдсазэн бол зүрхэнд туслах бөгөөд хялгасан судал тасарсаныг залгаж цус гарахыг зогсоох, зүрхний үнхэлцэгний бадганы ус, бүтээгч шар, түгмэл гүйгч хийн хорогдолыг нөхөн төлжүүлэх болно^{1-3,16-17}.

Сэржижима бол шээлгэх бөгөөд доод биеийн бадгана, шарын хорогдолыг нөхөн төлжүүлж хий, гүйдлийг сайжруулана. Дээрх найрлага нь найрлага нь амь баригч хий, дээш гүйгч хий, гал тэгшитгэгч хийг их хэмжээгээр нөхөн төлжүүлэх тул амь баригч хий, дээш гүйгч хий хоргдсоноос болсон өвчин өвчин хийгээд гал тэгшитгэгч хийг их хэмжээгээр нөхөн төлжүүлэх тул амь баригч хий, дээш гүйгч хий хорогдсоноос болсон өвчин хийгээд гал тэгшитгэгч хийн хорогдлоос болсон тунгалаг цөвийн ялгаралт муудах, ялангуяа тархи мэдрэлийн дотор оршсон гал тэгшитгэгч хийн доройтолыг нөхөн төлжүүлэх ба цулциран хэлгийрэх, ам хазайж мурийх, дурьшил буурах, үе мөч хөшиж атираа, зүрх мушгирч байх мэт санагдах, манарах, үхэтхийх зэрэгт тустай¹⁻². Урвуу арилгагч хийг бага хэмжээгээр нөхөн төлжүүлэх тул ууц нуруу шархиран өвдөх, суудал ясны хийн хорогдлоос болсон өвчнийг амирлуулана. Бадганыг дунд хэмжээгээр нөхөн төлжүүлэх тул зүрх түгших, толгой эргэх, олон үглэх, явахыг таалах, манарах, үхэтхийх, айх, цочих, чих шуугих, судал нарийн эрчимтэй түргэн лугших, шээс улайх, ам наалдангуй болох, тагнайн уг хуурайшин хөшүүн болох, нүдний судал улайх, мах хөхрөн хатах, хөдөлвөл уушги, зүрх дэлсэж, цээжээр халуун оргих, сэтгэлээс сэрүүн хүйтнийг хүсэх зэрэгт туслах болно.

Дүгнэлт:

1. Дээрх 29 хөл эмийн найрлага нь 7 эхүүн, 7 гашуун, 1 исгэлэн, 8 амтлаг, 5 халуун, 1 давслаг амтаар бүрэлдсэн. 10 хүнд, 17 мохдог, 14 хуурай, 16 ширүүн, 7 хурц, 3 шингэн, 10 бүлээн, 15 сэрүүн, 7 зөөлөн, 6 эелдэг, 4 хөлбөрөнхүй, 14 хөнгөн, 4 халуун, 9 тослог, 4 хүйтэн, 2 батлаг, 3 нүнжиггүй нийт 17 зүйлийн эрдэм бүгд оролцсон байна.
2. Тус найрлагын амтын эрдмээр хий, шар, бадганыг төлжүүлэхдээ 14 хуурай, 16 ширүүн, 15 сэрүүн, 4 хөлбөрөнхүй, 14 хөнгөн, 3 нүнжиггүй эрдмийн хүчээр хийн билиг чанарын хорогдолыг нөхөн төлжүүлж, гүйдлийг нь сайжруулан, хийн солилцоог нэмэгдүүлэнэ. 7 хурц, 10 бүлээн, 4 халуун, 9 тослог эрдмийн хүчээр шарын билиг чанарын хорогдолыг, 10 хүнд, 17 мохдог, 3 шингэн, 7 зөөлөн, 6 эелдэг, 9 тослог, 4 хүйтэн, 2 батлаг эрдмийн хүчээр бадганы билиг чанарын хорогдолыг тус тус нөхөн төлжүүлжээ.
3. Сампилноров үрэл эмийн амтын эрдмийн 7% нь хийг, 3 % нь шарыг, 6% нь бадганыг нөхөн төлжүүлэхэд тус тус оролцсон болно.

Ном зүй:

1. Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь. "Монгол анагаах ухаан". Хөх хот: Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо; 1986:862, 228, 233, 240, 241, 244, 292, 302, 317, 319, 325, 348, 379, 409, 489, 647, 650, 733, 781, 782, 790.
2. Ишбалжир. "Дөрвөн рашаан". Жамбалшонуй, Гомбо Ц нарын орчуулсан. Хөх хот: ӨМ-ын ардын хэвлэлийн хороо; 1998:130, 532, 533, 534.
3. Яай Чин Шияан. "Монгол-Төвд-Хятад хавсарсан эмийн нэрс". Улаанхад хот: ӨМ-ын Шинжлэх ухаан техник мэргэжлийн хороо; 1998:160.
4. Чулуунбаатар Г. Шинжлэх ухаан танин мэдэхүйн логик, судалгааны арга зүй. МУШУА Философи социологийн хүрээлэн. Улаанбаатар; 2001:101-105, 115-123.
5. Лодой Г. Философи ба шинжлэх ухааны арга зүй. Улаанбаатар; 2005:26-29, 32-36, 39-55.
6. Отгонбаяр М. Логик. Улаанбаатар; 2004:26, 70-73, 76-121.
7. Ковалченко И.Д. Методы исторического исследования. Москва; 2003:186-190, 190-195, 206-208, 232-244.
8. Жамбалсүрэн Ц. Түүх. Судалгааны арга зүй. Улаанбаатар; 2009:29-33.
9. Чулуунбаатар Г. "Шинжлэх ухаан танин мэдэхүйн логик, судалгааны арга зүй." МУШУА Философи социологийн хүрээлэн. Улаанбаатар; 2001:115-119.
10. Лодой Г. Философи ба шинжлэх ухааны арга зүй. Улаанбаатар; 2005:32-36.
11. Яай Чин Шияан. "Монгол эмийн жор." Хөх хот: ӨМӨЗО-ны ардын хэвлэлийн хороо; 1993:37-39, 46-47.
12. Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П. "Монгол эмийн судлал." Улаанбаатар; 2009:119, 121, 122, 178, 229, 278, 287.
13. Бөхбаатар. "Монгол эмийг хянан тогтоох судлал." Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо; 2008:227, 231, 425, 429, 436.
14. Лувсан Ч. "Монгол эмийн судлал." Хөх хот: Өвөр монголын үндэсний хэвлэлийн хороо; 1989:167, 185, 199, 220, 321-329.
15. Лувсан Ч. Монгол эмийн ойллого. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо; 1981.
16. "Өвөр монголын Монгол эмийн түүхий эдийн материалын баримжаа." Хөх хот: ӨМӨЗО-ны Шинжлэх ухаан техникийн мэргэжлийн хэвлэл; 1984:63, 72, 84.
17. Төмөрбагана. "Эмт бодис таних арга." Улаанхад хот: ӨМ-ын Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо; 1988:164-177, 192.
18. Сүрэнжав З. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал. Хөх хот: ӨМ-ын ардын хэвлэлийн хороо; 1991:45, 102, 141, 143.
19. Батцагаан. Ойрдын монгол эмч нарын туршилага. Нутгийн жор засал цуврал бичиг. Ашиа аймаг; 1991:321.
20. Даваадагва Д. "Монгол данжуурын доторх найман гишүүнтийн зүрхний хураангуйн дахь зарим тангийн судалгаа" эм зүйн ухааны докторын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: ЭМШУИС; 2011.
21. "Medicinal Plants in Thailand." Volume I. Department of Pharmaceutical Botany Faculty of Pharmacy, Mahidol University; 1996:145, 184, 185.
22. The Ayurvedic Pharmacopoeia of India Part 1. Volume 8. First edition. 2011. Cirrus Graphics Pvt. Ltd., New Delhi:1-12, 40-51, 89-100.
23. Hyperlipidemic Activity of Haritaki (Terminalia chebula) in Atherogenic Diet-Induced Hyperlipidemic Rats. J Adv Pharm Technol Res. 2010 Apr-Jun;1(2):227-235.
24. Kumudhaval MV, Vyasmohitand, Jaya Kar B. Pharmaceutical and Pharmacological Evaluation of the Plant Fruit of Terminalia Belerica Roxb. Int J Pharm Sci. Vinayaka Mission's College of Pharmacy, Salum-63008, Tamilnadu, India.
25. Pharmacopoeia of the People's Republic of China. Volume 2; 2005:88, 95, 112, 113.

The research on the analysis of Sampilnorov

Li Chan Shin¹, Yeruult Ch², Davaadagva D¹

¹Department of pharmaceutical technology, School of Pharmacy, MNUMS

²Department of Pharmacology, School of Bio Medicine, MNUMS

E-mail: 1554086502@qq.com, Tel: +976-90531451

Background: Traditional Mongolian medicine utilizes complex herbal formulations for restoring bodily functions and treating various ailments. Sampilnorov, a traditional medicinal composition, is recognized for its therapeutic properties in regenerating one of the 17 qualities and 15 functions of the human body, particularly qi and its associated functions.

Aim: This study aims to analyze the therapeutic potential of Sampilnorov in treating conditions related to vein disorders, fever, and musculoskeletal diseases.

Materials and Methods: A literature review was conducted, focusing on the *Mongolian Medicine* section of the *Medical Pharmacopoeia of the People's Republic of China*. The pharmacological properties, indications, and mechanisms of Sampilnorov were examined.

Results: The findings suggest that Sampilnorov is a valid therapeutic system in Mongolian traditional medicine for addressing multiple physiological dysfunctions. Further clinical and pharmacological studies are necessary to validate its efficacy and mechanisms of action.

Conclusion: Sampilnorov pills are traditionally used for Eliminating chronic fever and lesions in the white veins, Removing yellow fluid accumulation, Treating disorders of the black and white veins, such as paralysis, gout, rheumatism, and typhoid fever, Healing damaged veins and alleviating symptoms of leprosy, kidney vein concussions, kidney heat, vein and tendon spasms, and joint sprains.

Keywords: White vessels, Deficiency, Restoration, Balancing